



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2024 оны 01 сарын 12 өдөр

Дугаар 06

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Аймгийн Зоонозын өвчин судлалын төвд Эрүүл мэндийн яамны санхүүжилтээр хуваарилагдсан 13,999,700 /арван гурван сая есөн зуун ерэн есөн мянга долоон зуу/ төгрөгийн үнэтэй түргэвчилсэн полимеразын гинжин урвал /ПГУ/-ын машин /Quick mobile/-ыг үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр: Аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн дарга (Б.Алтантөгс)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

- 2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;
- 2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;
- 2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2021 оны 04 дүгээр сарын  
12-ний өдрийн 06 тогтоолын хавсралт

ЗӨСТөвийн Үндсэн хөрөнгөд бүртгэх хөрөнгийн мэдээлэл

№	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Нэгж үнэ	Тоо	Дүн
1	Түргэвчилсэн полимеразын гинжин урвал /ПГУ/-ын машин /Quick mobile/	ш	13,999,700.0	1	13,999,700.0
Тоног төхөөрөмжийн дүн				1	13,999,700.0